



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/790

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "л" заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарын албан хаагчид хамт олны зүгээс гаргасан өргөх бичгийг хянаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ариунбилэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Оюунчимэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

Л.Гэрэлмаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн


Х.Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Хяналт шалгалт хийх удирдамж гаргаж танилцуулахыг ажлын хэсэг /Д.Ариунбилэгт/-т даалгасугай.

3. Дүгнэлт гаргаж Засаг даргад болон Ховд аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Ариунбилэгт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/790-Bo